

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2018.06.22

Улаанбаатар хот

| Шийдвэр-ийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|--------------------------|---|--|--|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1.6.Улсын Их Хурлын тогтоол | | | | | |
| “Авилгатай тэмцэх үндсэний хөтөлбөр батлах тухай” 2016.11.03-ны өдрийн 51 тоот тогтоол | 2. | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авилгатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | <ul style="list-style-type: none"> - “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд тус байгууллага нь “НҮГ-ын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” гарган хэрэгжүүлж байна. - Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжтэй танилцаж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж буй бөгөөд өнөөдрийн байдлаар 1 албан хаагчийн талаар гомдол ирснийг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, ажлаас чөлөөлсөн. - АТГ, НЗДТГ-тай хамтран зохион байгуулсан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон худалдан авах үйл ажиллагаатай холбоотой сургалтад НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтсийн 18 албан хаагч хамрагдаад байна. Цаашид зохион байгуулагдах сургалтад нийт албан хаагчдыг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|-----|---|---|------|--|
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| 1.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | |
| 1.г.Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 1.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | |
| 1.е.Засгийн газрын тогтоол | | | | | |
| 2018 оныг “Хариуц- лагын жил” болгон зарлах тухай 2018.01.31- ний өдрийн 32 тоот тогтоол | 2.1 | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах | <p>Нийтийн эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - НЗЗ-ны байруудад байрлан ажиллаж буй ажилтан, албан хаагчдад эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал хэвшлийг сурталчлах зорилгоор Хангарди зоогийн газар, НЗДТГ-ын цайны газар, 5А байрны цайны газруудад ХУД-ийн ЭМН-тэй хамтарсан чихрийн шижинг тодорхойлох үзлэг хийж, цусны даралт ихсэх шалтгаан, зөв хооллолтын талаар мэргэжлийн зөвлөгөө өгч, өглөөний цайны өдөрлөгийг зохион байгуулсан. - ХСҮТ-ны хамтран 2018.04.27, 2018.05.05-ны өдрүүдэд НҮГ-ын ажилтан, албан хаагчдыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг, хэвлийн эхо, ходоодны дуран, рентген, толгой хүзүүний мэс засал, эмэгтэйчүүд, дотор зүрх судасны нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үзлэгт нийт 191 хүн хамрагдсан ба цаашид нэмэлт шинжилгээ хийлгэх, онош тодруулах шаардлагатай 7 хүнийг давтан шинжилгээнд хамруулж, эмчлүүлэх талаар ХСҮТөвтэй хамтран ажиллаж байна. <p>Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээнд манай байгууллагын 80 гаруй ажилтан албан хаагч | 100% | |

| | | | | | |
|--|-----|---|--|--|--|
| | | | <p>идэвх санаачилгатай оролцсон.</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын нийт ажилтан албан хаагчдын дунд 4 төрөлт спортын тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. - 2018.02.24-ний өдөр Хандгайтын цанын баазад болсон “Пенчён-2018” сэдэвт цасны баярт газрын 80 гаруй ажилтан, албан хаагч оролцож, НҮГ-ын БТС-ын хамтлаг 2017 оны ШИЛДЭГ хамтлагаар шалгарч цом, шагналыг гардан авсан. | | |
| | 2.2 | <p>яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах;</p> | <ul style="list-style-type: none"> - Удирдлагын зүгээс байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд байнга хяналт тавин, аливаа зөрчил, дутагдал гаргахаас сэргийлэн ажиллаж байна. - Өргөдөл гомдол хариуцсан албан тушаалтны зүгээс байгууллагад ирсэн 118 өргөдөл, гомдлыг тухай бүр www.smartcity.mn цахим системд бүртгэж, удирдлагад танилцуулан, шаардлагатай мэдээллээр хангаж, тайлант хугацаанд ирсэн бүх өргөдлийг шийдвэрлэн хариуг хүргүүлснээр шийдвэрлэлтийн явц 100 хувьтай хэрэгжиж байна. - Байгууллагад ирсэн өргөдөл гомдлын явцын тэмдэглэлийг 7 хоног бүр хөтлөн, хугацаанд нь, шуурхай шийдвэрлэж, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулахад анхааран ажиллаж байна. | 100% | |
| | 2.3 | <p>төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу</p> | <ul style="list-style-type: none"> - НҮГ-ын хэмжээнд нийт 1 ажилтан үр дүнгийн гэрээ, бусад ажилтан, албан хаагч хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажил үүргээ гүйцэтгэж байгаа билээ. - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт, Газрын даргын 2018 оны А/25 дугаар тушаалын дагуу НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчидтай | 95% Ажилтан, албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх хугацаа | |

| | | | | | |
|--|-----|--|---|-----------|--|
| | | хариуцлага тооцон ажиллаж байх; | байгуулсан хөдөлмөрийн гэрээний хагас жилийн биелэлт, үйлчилгээ техникийн ажиллагсдын хөдөлмөрийн гэрээний 2 дугаар улирлын биелэлтийг дүгнэж, ур чадварыг үнэлэх ажлыг 2018.06.25 - 2018.06.30-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. - Хөдөлмөрийн гэрээний биелэлт, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, ур чадварын үнэлгээг гаргаснаар гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажил үүрэгтээ хариуцлагагүй хандсан ажилтан, албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцно. | болоогүй. | |
| | 2.4 | 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах; | - Газрын даргын 2018.04.10-ны өдрийн А/23 тоот тушаалаар НҮГ-ын 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог томилсон. - НҮГ нь 2018 эхний хагас жилийн байдлаар нийт 8 ажлыг харьцуулалтын аргаар, бусад ажлыг шууд худалдан авалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, худалдан авах ажиллагаа явуулсан байна. | 100% | |
| | 2.5 | “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах. | - Газрын даргын 2018 оны А/09 дүгээр тушаалаар байгууллагын “Ёс зүйн дүрэм”-ийг, 2018 оны А/27 дугаар тушаалаар газрын “Хөдөлмөрийн дотоод журам” шинэчлэн баталж ажилтан, албан хаагчийн сахилга хариуцлага, дэг журмыг чангатган баримтлан ажиллаж буй болно. - ЗГ-ын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайланг сарын бүрийн 05-ны өдрийн дотор гаргаж, НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|--|------|---|---|------|--|
| | 4 | “Хариуцлагын жил”-ийн хүрээнд иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийг нийтийн эрх ашиг, үндэсний язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллахыг уриалсугай. | - Эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод газрын зүгээс хувь нэмрээ оруулах зорилгоор үйлчилгээ, техникийн ажиллагсдын дунд хариуцсан засаг захиргааны байрыг тохижуулах, сэргээн засварлах, шинэ бүтээл, оновчтой санаа гаргах чиглэл бүхий “Эрүүл, тохилог ажлын байр” сэдэвт болзолт уралдаан зохион байгуулсан. Уг болзолт уралдаанд нийт 17 баг оролцож, НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5А, 5Б, 5В байр болон зоогийн газрыг өөрсдийн нөөц боломжоор тохижуулж, сэргээн засварлах ажлууд хийгдсэн. | 100% | |
| Хэсгийн дундаж: 99,1 хувь | | | | | |
| 1.ё.Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| 1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 2018.04.04-ний өдрийн 16 дугаар тэмдэглэл | ХҮ 2 | Ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч | - 2018.04.04-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/509 дүгээр захирамжийг тус тус байгууллагын ажилтан, албан хаагчдад танилцуулан, ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх эрхийг бүрэн хязгаарласан болно. - Цаашид тус газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн 45 албан хаагч төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэн, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, ажлын бүтээмжийг | 100% | |

| | | | | | |
|---|-----|---|---|------|--|
| | | ажиллах | нэмэгдүүлэх боломжийг байнга эрэлхийлэн ажиллаж байна. | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| 1.3.Засгийн газрын албан даалгавар | | | | | |
| Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26-ны өдрийн 01 тоот албан даалгавар | 1.1 | Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх, Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах | <ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нийт ажилтан, албан хаагчдад сурталчлан таниулах зорилгоор байгууллагын 2018 оны 04 дүгээр сарын “Мэдээллийн цаг”-ийг зохион байгуулж, энэ үеэр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Ууганжаргал “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр нийт ажилтан, албан хаагчдад сургалт, мэдээлэл өгсөн. Дээрх сургалтад байгууллагын Захиргаа, санхүүгийн хэлтэс, Байр ашиглалтын алба, Үйлчилгээний албаны 250 гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан болно. - Мөн 2018 оны 05 дугаар сарын “Мэдээллийн цаг”-аар Улсын мөрдөн байцаах газрын мөрдөх албаны дүн шинжилгээ хяналт хариуцсан ахлах мөрдөн байцаагч дэд хурандаа Э.Нэмэхжаргал “Хариуцлага, сахилга бат, ёс зүй” сэдвээр мэдээлэл хийсэн. Тус мэдээлэлээр шинээр мөрдөгдөж буй хууль дүрэм, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, хувь хүний хариуцлага, сахилга бат, ёс зүйн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн болно. | 100% | |
| | 1.2 | Авлигын хяналтыг сайжруулах, Төрийн албыг хувийг ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүрт нь таслан зогсоож, авлига, хээль хахууль, хүнд суртал, шударга | <p>“Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд гаргасан “НҮГ-ын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу дараах ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байрны сул орон тооны зар, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг www.khangardi.mn сайтад | 100% | |

| | | | | | |
|--|-----|---|--|------|--|
| | | бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх | <p>байршуулан нийтэд мэдээлж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Мэдүүлэг гаргагч 9 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг зохих журмын дагуу гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна. | | |
| | 1.3 | Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх, “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн, дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүх хариуцлага тооцож ажиллах | <ul style="list-style-type: none"> - Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 118 өргөдөл ирснээс 118 өргөдлийг шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд биечлэн хүргүүлсэн байна. Байгууллагад ирсэн өргөдлийг чиглэлээр нь тодруулбал чөлөө хүсэх тухай өргөдөл 30, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 33, тэтгэмж тусламж хүссэн өргөдөл 12, цалин хөлстэй холбоотой хүсэлт 25, байгууллага дотор шилжин ажиллах хүсэлт 5, ээлжийн болон жирэмсний амралт авах тухай өргөдөл 6, бусад чиглэлээр 9 өргөдөл иржээ. - Цаашид ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын явцын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, хугацаанд нь шийдвэрлэн, хариуг биечлэн өгч, зөрчил гаргахгүй байхад анхааран ажиллана. | 100% | |
| | 1.4 | Төрийн албаны үр ашгийг сайжруулах, Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих | <ul style="list-style-type: none"> - НҮГ-ын нийт ажиллагсад 2018.04.15-ны өдрөөс 08 цаг 00 минутанд ажлаа эхлүүлж, ажлын цагийг чанд баримтлан ажиллаж байгаа бөгөөд ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр бүртгэн, ажлын байранд үүрэгт ажлаа чанартай үр дүнтэй хийж байгаа эсэхэд дотоод хяналт хариуцсан ажилтан болон хүний нөөцийн ажилтнаас хяналт тавин ажиллаж байна. Мөн ажлын цаг ашиглалтад ажлын 5 хоног бүр хяналт шалгалт | 100% | |

| | | | | | |
|---|-----|--|---|---|--|
| | | | <p>хийж, дүнг газрын шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын нийт ажилтан, албан хаагчидтай шинэчилсэн хөдөлмөрийн гэрээг байгуулж баталгаажуулсан. - Газрын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон ажилтан бүрийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн гаргаж, ажилтан, албан хаагчдад танилцуулан хэрэгжүүлэх болсноор нийт ажиллагсдын ажлын бүтээмж нэмэгдсэн эерэг үр дүнтэй байна. | | |
| Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26-ны өдрийн 01 тоот албан даалгавар | 2.1 | Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн явц үр дүнд тавих хяналтыг сайжруулан, хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах | <ul style="list-style-type: none"> - Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг шуурхай зохион байгуулан, гүйцэтгэлийн явц үр дүнд тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал 9 удаа хуралдаж, ажилтан бүрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар үүрэг даалгавар өгч ажилласан байна. - Захиргаа, санхүүгийн ажиллагсдын шуурхай зөвлөгөөн нийт 8 удаа хуралдаж, газрын хэмжээнд шийдвэрлэх асуудлыг шуурхай зөвлөлдөн, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг эргэн танилцуулан эргэх холбоотой ажиллаж байна. | 100% | |
| | 2.2 | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулж ажиллах | <ul style="list-style-type: none"> - Манай газар нь хууль тогтоомжид заасан лиценз, үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, газар олгох эрхийг олгодоггүй болно. | 100% Уг заалт нь манай байгууллагын бүрэн эрхэд хамаарахгүй тул хяналтаас хасуулах саналтай байна. | |

| | | | | | |
|--|-----|--|---|------|--|
| | 2.3 | Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн, иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх | <ul style="list-style-type: none"> - НҮГ-ын үйл ажиллагааг холбогдох стандартад нийцүүлэн сайжруулах, төрийн албан хаагчдын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2018.03 дугаар сард НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5А, 5Б байр болон НҮНТ-ийн Дүнжингарав, Драгон, Мишээл салбаруудад ажиллаж буй 1556 албан хаагчийг хамруулсан сэтгэл ханамжийн нээлттэй асуулга явуулсан. Газрын зүгээс дээрх асуулгын үр дүнгээс гарсан санал, хүсэлтэд тулгуурлан цаашид төрийн албан хаагчдын эрүүл, аюулгүй, ажлын байрны таатай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлснээр НЗЗ-ны 1, 2 дугаар байрны зоогийн газар нь 142 нэр төрлийн хоол зууш үйлдвэрлэж, 14 хоногийн давтамжтай гаргасан менюгаар үйлчилж байна. Үүний үр дүнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар давхацсан тоогоор өдрийн зоогийн үйлчилгээг 16800 хүнд, 29 хүлээн авалтаар 1147 хүнд, 5 удаагийн хурлын цайны завсарлагаар 1360 хүнд үйлчилснээр хүлээн авалтын тоо хэмжээ 48,2%-иар, үйлчлүүлэгчдийн тоо 53,4%-иар өссөн үзүүлэлттэй байна. - НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, урьдчилан сэргийлэх үзлэг хийхийн зэрэгцээ эвдрэл, гэмтэл гарсан тухай нийт 2398 дуудлагын дагуу манай инженер, техникийн 19 ажилтан үзлэг хийж, гарсан эвдрэл гэмтлийг газар дээр нь шуурхай засварлаж ажилласан байна. | 100% | |
| | 2.4 | Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, | - Хариуцсан ажил үүрэгтээ хайнга хариуцлагагүй хандсан, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан нийт 17 | 100% | |

| | | | | | |
|--|-----|---|---|---|--|
| | | ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх | ажилтанд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал болон Ёс зүйн зөвлөлийн хурлаас сахилгын шийтгэл ногдуулах санал гарч 12 ажилтанд сануулах сахилгын шийтгэл, 5 ажилтанд хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулсан. | | |
| | 2.5 | Удирдлага, ажилтнуудын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах | <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт, Газрын даргын 2018 оны А/25 дугаар тушаалын дагуу ажилтан, албан хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хагас жилийн биелэлт, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2018.06.25-ны өдрийн дотор гаргаж дүгнэн, ур чадварыг үнэлэх ажлыг 2018.06.25-ны өдрөөс 2018.06.30-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. - 2018 оны 1, 2 дугаар улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж, ажил үүрэгтээ хариуцлагагүй хандсан 17 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан болно. | 100% | |
| | 4. | Нутгийн өөрөө удирдах болон захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна. | <ul style="list-style-type: none"> - НҮГ-ын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь төрийн албан хаагчийн ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход чиглэх учир иргэдээс манай байгууллагад хандсан өргөдөл, гомдол ирдэггүй болно. | 100% Уг заалтыг хяналтаас хасуулах саналтай байна. | |

| | | | | | |
|--------------------------|----|--|---|------|--|
| | 5. | Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна. | - НҮГ нь Засгийн газрын 2017 оны 01 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн тайланг сарын бүр гарган, НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж буй болно. | 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| Нийт дундаж: 99,7 хувь | | | | | |

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.ХОРОЛДУЛАМ